



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/1163

Улаанбаатар хот


Манай хороо-Миний гудамж аян зохион
байгуулахад шаардагдах хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2019 оныг “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан “Манай хороо-Миний гудамж” аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн нийслэлийн 9 дүүрэгт батлагдсан хуваарийн дагуу ажиллахад авто тээврийн хэрэгслийн шатахууны зардалд шаардагдах хөрөнгийг хавсралт ёсоор баталсугай.

2. Дээрх ажилд шаардагдах 2.055.240 /Хоёр сая тавин таван мянга хоёр зуун дөчин/ төгрөгийг Шилдэг тохижилттой аж ахуй нэгж, байгууллага шалгаруулах уралдааны болзлын зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт ажиллаж, хийгдэж буй ажилд хяналт, үзлэг шалгалт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны *Овдугаар* сарын *13* өдрийн
А/163 тушаалын хавсралт



ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хийгдэх ажил	Ажлын хэсэг	Авто машины марк	100 км бензин зарцуулалт	Тоо хэмжээ	Нэгж үнэлгэ э /төг/	Төсөв /сая.төг /
1	"Манай хороо-Миний гудамж" аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний шатхууны зардал /Улаанбаатар хотын Ерөнхий менежерээр батлуулсан ажлын хэсэг нийт 48 хүний бүрэлдэхүүн нийслэлийн 9 дүүрэгт ажиллана/	1-р ажлын хэсэг /16 хүний бүрэлдэхүүнтэй 3 машин/	1. Toyota Harrier 2. Toyota Prius-30 3. Sonata-6	20 литр 8.2 литр 16 литр	1. Багануур дүүрэг: 1 талдаа 130 км*2=260 км*1940 төг=65.740 төг 2. Баянзүрх дүүрэг: 1 талдаа 30 км*2=60 км*1940 төг=13.840 төг 3. Хан-Уул дүүрэг: 1 талдаа 30 км*2=60 км*1940 төг=13.840 төг	93.420 төг *3 машин *3 удаа	840.780
2		2-р ажлын хэсэг /16 хүний бүрэлдэхүүнтэй 3 машин/	1. Toyota Harrier 2. Toyota Prius 3. Sonata-7	20 литр 8.2 литр 17.6 литр	1. Багахангай дүүрэг: 1 талдаа 110 км*2=220 км*1940 төг=55.360 төг 2. Баянгол дүүрэг: 1 талдаа 20 км*2=40 км*1940 төг=12.110 төг 3. Сонгинохайрхан дүүрэг: 1 талдаа 30 км*2=60 км*1940 төг=13.840 төг	81.310 төг *3 машин *3 удаа	731.790
3		3-р ажлын хэсэг /16 хүний бүрэлдэхүүнтэй 3 машин/	1. Toyota Harrier 2. Toyota Prius-30 3. Sonata-6	20 литр 8.2 литр 16 литр	1. Налайх дүүрэг: 1 талдаа 50 км*2=100 км*1940 төг=25.950 төг 2. Сүхбаатар дүүрэг дүүрэг: 1 талдаа 30 км*2=60 км*1940 төг=13.840 төг 3. Чингэлтэй дүүрэг: 1 талдаа 30 км*2=60 км*1940 төг=13.840 төг	53.630 төг *3 машин *3 удаа	482.670
НИИТ							2.055.240